**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 21 өдөр　　　　Дугаар Б/08　　　　Дадал сум

Онон багийн Засаг даргаар О.Дугарыг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.2, 56.4, 56.6 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.17 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Онон багийн Иргэдийн Нийтийн Хурлаас олонхийн санал авч нэр дэвшин Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05/5174 дугаартай албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсээгүй дүгнэлт гарсан Очирбатын Дугарыг 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс Онон багийн Засаг даргаар томилсугай.

2.О.Дугарын үндсэн цалинг 1,458,000 (Нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгөөр тогтоон онцгой нөхцөлийн 30 (гуч) хувь, орон нутгийн нэмэгдэл 60 (жар) хувиар тооцон олгохыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-д даалгасугай.

3.О.Дугарт ажилдаа хурдан суралцаж, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөөгөө батлуулан, батламж гэрээг хэрэгжүүлж, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргаж мэдүүлэхийг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА　　　　Ш.МӨНХХУЯГ

010000187